



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/489

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/38 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/-Цаг уурын өртөөний барилгын их засвар /Булган, Хутаг-Өндөр/-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Хурмастын хүлэг” ХХК-тай 93 512 845 (ерэн гурван сая таван зуун арван хоёр мянга найман зуун дөчин тав) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (Ш.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Хурмастын хүлэг” ХХК-ийн захирал (Г.Ганзориг)-д даалгасугай.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010615

07 дугаар сарын 02-ний өдрийн 1/489 дугаар захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын 2024 оны

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Захиалагчийн албаны зардал	1,452,211	Ү.Бямбасүрэн
2	Нормчлолын сан	130,699	Ү.Бямбасүрэн
3	Магадлашгүй ажил	1,452,211	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	726,106	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	3,500,000	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн